

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР, БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ ШИНЭЧЛЭН
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Эрүүл мэндийн яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:
 - 2.1. Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс; Гадаад харилцааны хэлтэстэй);
 - 2.2. Бодлого төлөвлөлтийн газар (Стратеги удирдлагын хэлтэс; Судалгаа, төлөвлөлтийн хэлтэстэй);
 - 2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтэс; Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтэс; Уламжлалт анагаах ухааны хэлтэстэй);
 - 2.4. Нийтийн эрүүл мэндийн газар (Халдварт өвчний хэлтэс; Халдварт бус өвчний хэлтэс; Урьдчилан сэргийлэлт, хяналт зохицуулалтын хэлтэстэй);
 - 2.5. Санхүү, эдийн засгийн газар (Хөрөнгө оруулалтын хэлтэс; Санхүү, даатгалын хэлтэстэй);
 - 2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.
3. Эрүүл мэндийн яамны орон тооны хязгаарыг 100 байхаар тогтоосугай
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 155 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Эрүүл мэндийн сайд С.ЭНХБОЛД